




БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



БОУАӨЯ-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР



ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ХӨРГӨЛТТЭЙ АГУУЛАХЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Чадамжид
суурилсан сургалтын
хөтөлбөрийн эмхэтгэл

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС
2025



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



БОУАӨЯ-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР

**Хөргөлтийн тоног төхөөрөмжийн мэргэжилтнийг
мэргэшүүлэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр**

ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ХӨРГӨЛТТЭЙ АГУУЛАХЫН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ

**ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН
ХӨТӨЛБӨРИЙН ЭМХЭТГЭЛ**

УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС
2025



MINISTRY OF ENVIRONMENT
AND CLIMATE CHANGE



NATIONAL OZONE AUTHORITY



UNITED NATIONS ENVIRONMENT
PROGRAMME

COMPETENCY-BASED TRAINING PROGRAM
for Certification of Refrigeration Equipment Repairman, Technicians

**Maintenance and Servicing of Cold Storage
and Refrigerated Warehouse in the Food
Production and Commercial Sector**

Compilation of the Competency-Based Training Curriculum

Ulaanbaatar
Mongolia
2025

Агуулга

ХӨТӨЛБӨРИЙН НЭР, ЗОРИУЛАЛТ	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА	9
ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ	12
ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ...	13
Нэг. Үндэслэл	13
Хоёр. Сургалтын хөтөлбөрийн онцлог, давуу тал	16
Гурав. Сургалтын хөтөлбөрийг ашиглах хувилбар	18
Дөрөв. Зөвлөмж	18
МОДУЛЬ 1	
МОДУЛЬ 1 ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ	22
“БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ХӨРГӨХ БОДИС СОНГОХ” чадамжийн нэгжийн бүтэц	22
“ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЕД ХӨРГӨХ БОДИСТОЙ ХАРЬЦАХ” чадамжийн нэгжийн бүтэц	27
“ХӨРГӨХ БОДИСЫГ ЮҮЛЭХ” чадамжийн нэгжийн бүтэц	31
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	36
ҮНЭЛГЭЭ	38
МОДУЛЬ 1 сургалтын цагийн хуваарилалт, төлөвлөгөө	45
МОДУЛЬ 2	
МОДУЛЬ 2 ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ	46
“АЖЛЫН БАЙРНЫ ХАБЭА-Г ХАНГАХ” чадамжийн нэгжийн бүтэц	46
“ШУГАМ ХООЛОЙ ЗАСВАРЛАХ буюу ШУГАМ ХООЛОЙГ БОЛОВСРУУЛАХ” чадамжийн нэгжийн бүтэц	51
“СИСТЕМИЙН БИТҮҮМЖЛЭЛ ШАЛГАХ” чадамжийн нэгжийн бүтэц	55
“СИСТЕМИЙГ ВАКУУМДАХ” чадамжийн нэгжийн бүтэц	60
“СИСТЕМИЙГ ХӨРГӨХ БОДИСООР ЦЭНЭГЛЭХ” чадамжийн нэгжийн бүтэц	63
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	67
ҮНЭЛГЭЭ	69
МОДУЛЬ 2 сургалтын цагийн хуваарилалт, төлөвлөгөө	80
МОДУЛЬ 3	
МОДУЛЬ 3 ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ.....	81
“ХӨРГӨЛТИЙН СИСТЕМИЙН ДАРАЛТЫГ ШАЛГАХ” чадамжийн нэгжийн жагсаалт	81
“ХӨРГӨЛТИЙН КОМПРЕССОРТ ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ” чадамжийн нэгжийн бүтэц	86

“ХӨРГӨЛТИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АЖИЛЛУУЛЖ ШАЛГАХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	89
“УУРШУУЛАГЧИД ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ” чадамжийн нэгжийн бүтэц	93
“ХӨРГӨЛТИЙН КОНДЕНСАТОРТ ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	98
“ЦАХИЛГААН, АВТОМАТ ТӨХӨӨРӨМЖҮҮДЭД ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	103
“ХЭМЖИХ, ХЯНАХ ХЭРЭГСЭЛД ҮЗЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	108
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	113
ҮНЭЛГЭЭ	115
МОДУЛЬ 3 сургалтын цагийн хуваарилалт, төлөвлөгөө	124
МОДУЛЬ 4	
МОДУЛЬ 4 ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ	125
“ГЭМТЛИЙН ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	125
“ХӨРГӨХ БОДИСЫГ РЕСИВЕРТ ХУРААХ” чадамжийн нэгжийн бүтэц	129
“ХӨРГӨЛТИЙН КОМПРЕССОР ЗАСВАРЛАХ”	
чадамжийн нэгжийн бүтэц	133
“ЦАХИЛГААНЫ ГЭМТЛИЙГ ЗАСВАРЛАХ” чадамжийн нэгжийн бүтэц	137
“КОНДЕНСАТОР ЗАСВАРЛАХ” чадамжийн нэгжийн бүтэц	140
“УУРШУУЛАГЧ ЗАСВАРЛАХ” чадамжийн нэгжийн бүтэц	144
СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА	147
ҮНЭЛГЭЭ	149
МОДУЛЬ 4 сургалтын цагийн хуваарилалт, төлөвлөгөө	158
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ	160

Сургалтын хөтөлбөрийн нэр

Хүнс үйлдвэрлэл, худалдааны салбарын хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажилтанд зориулсан **“Хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлттэй агуулах, зоорийн засвар, үйлчилгээ”** Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр

Сургалтын хөтөлбөрийн зориулалт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 784 дугаартай Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дүгнэлтээр баталгаажсан тул сургалтын байгууллага, аж ахуй нэгж инженер, техникийн ажилтнууд, хүнс, худалдааны хөргөлтийн чиглэлээр суралцах сонирхолтой иргэд, залуучуудыг модульчилсан сургалтаар сургах, чадавхжуулах, давшан сургах зорилгоор ашиглах боломжтой.

Хөтөлбөр нь нийт 4 модуль, 21 чадамжийн нэгж бүхий 160 цагийн хөтөлбөр болно.

Энэхүү сургалтын хөтөлбөрийг Монгол Улсад “ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын хэрэглээг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд боловсруулан, хянан тохиолдуулж, Монреалийн протоколыг хэрэгжүүлэх Олон талт сангийн санхүүжилтээр хэвлүүлэв.

Preface

This competency-based training curriculum, “Maintenance and Servicing of Cold Storage and Refrigerated Warehouse in the Food Production and Commercial Sector”, has been validated under Validation of the curriculum No. 784 issued by the Director of the Institute for Training, Assessment, and Research on Labor and Social Protection on 09 November 2023.

The program is designed for training institutions, enterprises, engineers, technical staff, and individuals—particularly youth—interested in developing practical skills in refrigeration for food production and trade. It provides a structured modular approach for initial training, capacity building, and refresher training.

The curriculum consists of four modules and twenty-one competency units, totaling 160 instructional hours, ensuring participants acquire the knowledge and skills necessary to perform effectively in the sector.

This competency-based training program was developed and published under the HCFC Phase-out Management Plan (HPMP) for Mongolia to support compliance with national and international obligations under the Montreal Protocol and to strengthen capacity for the sustainable phase-out of HCFCs.

Хөтөлбөрийг Хөдөлмөрийн сайдын А/197 загварын дагуу боловсруулсан

- | | |
|-------------------|---|
| 1. Ж.Мөнхзул | Мэргэжлийн боловсрол, сургалтын “Зөвлөх багш”,
Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр ба
үнэлгээний үндэсний сургагч |
| 2. Ш. Энх-Амгалан | “Хөргөлтийн шинэ эрин” сургалт, судалгааны
төвийн тэргүүн, Монгол Улсын зөвлөх
инженер, (Ph.D) |
| 3. П. Алтанцэцэг | Хүнсний үйлдвэрлэл, технологийн их
сургуулийн Инженерийн тэнхимийн
хөргөлтийн багш |

Хянаж, арга зүйгээр хангаж ажилласан:

- | | |
|-----------------|---|
| 1. Д.Дуламсүрэн | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
яамны Озоны үндэсний албаны ахлах
мэргэжилтэн, хөтөлбөрийн зохицуулагч,
(MSc, MA) |
| 2. Н.Алтанчимэг | ХНХ-ын сургалт, үнэлгээ, судалгааны
институтын арга зүйч, мэргэжлийн боловсрол,
сургалтын “Тэргүүлэх багш” |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АА	Аюулгүй ажиллагаа
АМС	Ажил мэргэжлийн стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ГШҮ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
ГЦХ	Гүйцэтгэлийн цар хүрээ
ГХФН	Гидрохлортфторт нүүрстөрөгч (HCFC-Hydrochlorofluorocarbons)
ГФН	Гидрофторт нүүрстөрөгч (HFC- Hydrofluorocarbons)
ДДНЧ	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар
DACUM	Development a curriculum
МБСС	Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МУ	Монгол улс
МЧХ	Мэдлэг, чадвар, хандлага
МХХАХ	Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НУ	Нүүрсустөрөгч (HC-Hydrocarbon)
НҮБ	Нэгдсэн Үндэстний байгууллага
ОЗЧ	Озон задлах чадвар
ОУА	Озоны үндэсний алба
ОЗБ	Озон задалдаг бодис (Ozone Depleting Substance)
GSP	Сайн арга туршлага (Good Servicing Practice)
ҮАМАТ	Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
ҮМТХ	Үндэсний мэргэшлийн түвшний хүрээ
ХТТ	Хөргөлтийн тоног төхөөрөмж
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХАБ	Хөдөлмөрийн аюулгүй байдал
ЧН	Чадамжийн нэгж
ЧЭ	Чадамжийн элемент
ЧСС	Чадамжид суурилсан сургалт
ЭЗМ	Эзэмшвэл зохих мэдлэг

ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн нэр:	Хүнс үйлдвэрлэл, худалдааны салбарын хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажилтанд зориулсан “Хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зөв дадал (GSPs)-д тулгуурласан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр
Хөтөлбөрийн индекс:	0713-08
Чадамжийн нэгжийн тоо:	Нийт 4 модуль, 21 чадамжийн нэгж, 160 цаг

Хөтөлбөрийн үндэслэл:

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Озоны үндэсний алба (ОУА) “ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийн хүрээнд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөртэй хамтран “ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДААНЫ ХӨРГӨЛТИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКЧДЭД ХӨРГӨЛТИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗӨВ ДАДАЛ (GSP) ОЛГОХ” сургалтыг зохион байгуулж ирсэн бөгөөд дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Озоны үндэсний албаны захиалгаар Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбооны оролцоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа МБС-ын ҮМАЗТ (хуучнаар) “Хөргөлтийн тоног төхөөрөмжийн техникч”, “Агааржуулалт (кондиционер)-ын тоног төхөөрөмжийн техникч” мэргэжлүүдийн ажил мэргэжлийн стандарт боловсруулан баталгаажуулснаар энэхүү сургалтын хөтөлбөрийг зөв дадал GSP-д олгох чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага бий болсон юм.

“ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын хэрэглээг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийн II шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах судалгааны үр дүн, I дүгээр үе шатны хэрэгжилтээс гарсан сургамжид үндэслэн хүнс, хоол боловсруулах салбарын хөргөлттэй агуулах/зоорийн хөргөх бодисын хэрэглээний түвшин өндөр, засвар үйлчилгээний сайн арга туршлага/зөв дадал болон хөргөх бодис юүлэх талаар мэдлэг, мэдээлэл бага, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) бага орлуулах технологи хэдийн нэвтэрсэн, цаашид манай орны зах зээлд байгальд ээлтэй байгалийн хөргөх бодис (пропан, изо-бутан, аммиак, нүүрсхүчлийн хий г.м.)-т суурилсан хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэрэглээ

нэмэгдэх чиг хандлагатай байгаа нь энэхүү сургалтыг зохион байгуулах үндэслэл болж байна” хэмээн [ОУА-ны сургалтын хөтөлбөр 2022 оны 05 сарын 03-04] ОУА-аас дүгнэсэн байдаг.

Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколоор зохицуулдаг ГХФН/НСFC төрлийн хөргөх бодисын үйлдвэрлэл, хэрэглээг үе шаттай бууруулан 2030 оны 01 сарын 01 гэхэд үйлдвэрлэл, экспорт, импортыг зогсоож бүрмөсөн хэрэглээнээс гаргах бөгөөд Монгол Улс озон задалдаг бодис (ОЗБ)-ын үйлдвэрлэл, импорт, хэрэглээг үе шаттай бууруулж, хэрэглээнээс халах энэхүү үүргийг хүлээдэг.

НҮБ-ийн Байгаль орчны хөтөлбөр (UNEP) нь гол хэрэгжүүлэгч агентлаг, Япон Улс хамтран хэрэгжүүлэгч агентлаг юм. Хөтөлбөрийн I үеийн 4 дүгээр буюу сүүлийн шат (tranche)-ыг ExCom-ын 85 дугаар хурлаар баталсан бөгөөд 2021 оны 12 сард I үе хэрэгжиж дууссан ба ExCom-ын 86 дугаар хурлаар ГХФН/НСFC төрлийн бодисыг хэрэглээнээс халах зорилгоор Монгол Улсын HPMP хөтөлбөрийн II үеийг 2020-2030 онд хэрэгжүүлэхээр батлаад байна. 2021 оноос хөтөлбөрийн II үеийн 1 дүгээр шатны үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хоол, хүнс боловсруулах салбарын хөргөлттэй агуулах/зоорийн хөргөх бодисын хэрэглээний түвшин өндөр, засвар үйлчилгээний сайн арга тугшлага/зөв дадал болон хөргөх бодис юүлэх талаар мэдлэг, мэдээлэл бага, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) бага орлуулах технологи хэдийн нэвтэрсэн, цаашид манай орны зах зээлд байгальд ээлтэй байгалийн хөргөх бодис (пропан, изо-бутан, аммиак, нүүрсхүчлийн хий г.м.)-т суурилсан хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэрэглээ нэмэгдэх чиг хандлагатай байгаа нь энэхүү сургалтыг хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл болсон.

Хөтөлбөрийн зорилго:

Япон Улсын бүрэлдэхүүн хэсгээс санхүүжих техникийн туслалцааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд Хөргөлтийн засвар үйлчилгээний салбарын чадавхыг бэхжүүлэх хэсгийн 2-т заасан Хүнс үйлдвэрлэл, худалдааны салбарын хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажилтнуудад зориулсан “Хөргөлттэй агуулах, зоорийн засвар, үйлчилгээ”-нд Засвар үйлчилгээний зөв дадал (GSPs)-д (НСFC бүлгийн R22 болон R404A холимог хөргөх бодисын алдагдал илрүүлэх, хөргөх бодисыг юүлэх, дахин ашиглах) тулгуурласан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг баталгаажуулан, хэлэлцүүлэг зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт:

Байгаль орчинд ээлтэй хөргөх бодис сонгох болон хууль эрх зүйн орчинтой танилцах, засвар үйлчилгээний үед хөргөх бодистой ажиллах орчны эрсдэлийг тодорхойлох, аюулгүй ажиллах зарчмуудтай танилцах,

- Хөргөх бодисыг вакуумдах, юүлэх үеийн онцлогууд, хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний тусгай багаж төхөөрөмжүүдийн талаар болон хөргөх бодис болон тосны ангиалал, нэр төрөл, ашиглалтын үеийн нөхцлийн тухай танилцана.
- Ажлын байрны ХАБЭА-г хангах, шугам хоолой засварлах (Шугам хоолойг боловсруулах) чадварыг эзэмшинэ.
- Системийн битүүмжлэл шалгах (Хөргөх бодисын алдагдал илрүүлэх), системийг вакуумдах, системийг хөргөх бодисоор цэнэглэх, хөргөлтийн системийн даралтыг шалгах чадамж эзэмшинэ.
- Хөргөлтийн компрессорт, хөргөлтийн тоног төхөөрөмжийг ажиллуулж шалгах, ууршуулагчид, хөргөлтийн конденсаторт, цахилгаан, автомат төхөөрөмжүүдэд болон хэмжих, хянах хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийх чадамж эзэмшинэ.
- Гэмтлийн шалтгааныг тодорхойлж, хөргөх бодисыг ресиверт хураах, хөргөлтийн компрессор, цахилгааны гэмтэл, конденсатор, ууршуулагч засварлах мэдлэг, хандлага, ур чадварыг эзэмшинэ.

1.1 Хүрэх үр дүн:

- Хөргөлтийн техникийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, тэдгээртэй холбогдох олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт, стандарт, Монреалийн протоколоор зохицуулдаг хөргөх бодисууд (ГХФН/HCFC, ХФН/HFC)-ыг орлуулах шатамхай, өндөр даралттай, хортой хөргөх бодисуудын засвар үйлчилгээний зөв дадал/сайн арга туршлага (GSPs-Good servicing practices) аюулгүй ажиллах мэдлэг эзэмшсэн байна.
- Хөргөх бодистой засвар үйлчилгээний үед харьцах, вакуумдах, юүлэх үеийн онцлог, хөргөлт, агааржуулалтын засвар үйлчилгээний тусгай багаж төхөөрөмжүүдийг ашиглах, тосны ангиалал, ашиглалтыг нөхцлийг тодорхойлж, сонгох, багаж хэрэгсэл бэлтгэх, хөргөх бодисыг юүлэх чадамж эзэмшсэн байна.
- Мөн мэргэжлийн түвшинд хөргөлтийн системийн даралтыг шалгах, компресор, конденсатор, ууршуулагчид үзлэг үйлчилгээ хийх, цахилгаан болон автомат хэрэгсэл, тоноглолд үзлэг хийх мэдлэг, чадвартай болсон байна.
- Өндөр даралттай болон шатамхай хөргөх бодисын мэдлэгтээ тулгуурлан ашиглахдаа өөрийн болон бусдын аюулгүй орчныг хангах, бүрдүүлэх талаар шаардлага тавих, бүрдүүлж ажиллах хариуцлагатай болсон байна.
- Хөргөлтийн системд үзлэг, үйлчилгээг тогтмол хийж, гэмтлийг тодорхойлж, засварлаж сурсан байна.

ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
Модуль 1		
1	Байгаль орчинд ээлтэй хөргөх бодис сонгох	0713-08-01
2	Засвар үйлчилгээний үед хөргөх бодистой харьцах	0713-08-02
3	Хөргөх бодисыг юүлэх, дахин боловсруулах	0713-08-03
Модуль 2		
4	Ажлын байрны ХАБЭА-г хангах	0713-08-04
5	Шугам хоолой засварлах (Шугам хоолойг боловсруулах)	0713-08-05
6	Системийн битүүмжлэл шалгах (Хөргөх бодисын алдагдал илрүүлэх)	0713-08-06
7	Системийг вакуумдах	0713-08-07
8	Системийг хөргөх бодисоор цэнэглэх	0713-08-08
Модуль 3		
9	Хөргөлтийн системийн даралтыг шалгах	0713-08-09
10	Хөргөлтийн компрессорт үзлэг үйлчилгээ хийх	0713-08-10
11	Хөргөлтийн тоног төхөөрөмжийг ажиллуулж шалгах	0713-08-11
12	Ууршуулагчид үзлэг үйлчилгээ хийх	0713-08-12
13	Хөргөлтийн конденсаторт үзлэг үйлчилгээ хийх	0713-08-13
14	Цахилгаан, автомат төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийх	0713-08-14
15	Хэмжих, хянах хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийх	0713-08-15
Модуль 4		
16	Гэмтлийн шалтгааныг тодорхойлох	0713-08-16
17	Хөргөх бодисыг ресиверт хураах	0713-08-17
18	Хөргөлтийн компрессор засварлах	0713-08-18
19	Цахилгааны гэмтлийг засварлах	0713-08-19
20	Конденсатор засварлах	0713-08-20
21	Ууршуулагч засварлах	0713-08-21

ЧАДАМЖИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1 Боловсролын багц хууль шинэчлэгдэн батлагдаж, мэргэжлийн сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дараах эрх зүйн актууд баталгаажиг гарсан. Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсгийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2024 оны А/29, А/04 тушаалаар “Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журам” баталсан;
2. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/513, А/171 дугаар тушаалаар “Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журам” баталсан;
3. Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/13 дугаар тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдөд олгох боловсролын баримт бичгийн загвар, түүнийг хөтлөх, олгох журам” баталсан;
4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тус тус эрх зүйн актуудыг баталсан.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэгт “Сургалтын хөтөлбөрийг түншлэлийн оролцоог хангаж ажил, мэргэжлийн стандартад нийцүүлэн боловсруулна” гэж заасны дагуу тус хөтөлбөрийг “ГХФН/НСФС төрлийн хөргөх бодисын хэрэглээг үе шаттай бууруулах менежментийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Озоны үндэсний албаны захиалгаар Монголын хөргөлт, халаалт, агааржуулалтын холбоо, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа МБС-ын ҮМАЗТ (хуучнаар) хамтран боловсруулсан “Хөргөлтийн тоног төхөөрөмжийн техникч” мэргэжлийн ажил мэргэжлийн стандартад тусгасан 61 чадамжийн нэгжийг багтаан боловсруулалт хийсэн.

Иймд тус боловсруулсан хөтөлбөрүүдээр суралцаж төгсөгч нь чадамжийн гэрчилгээ авах боломж бүрдэж байгаа нь тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үндэслэл болж байна.

Мөн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Политехник коллеж нь мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно”, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт “Мэргэжлийн боловсролын сургууль нь мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно” заасны дагуу тус боловсруулсан хөтөлбөрүүдийг мэргэжлийн сургалтын төвөөс гадна мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежууд хэрэгжүүлэх боломжтой юм.

Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллеж төгссөн болон хөдөлмөрийн зах зээл дээр ажиллаж байгаа иргэд богино хугацаанд мэргэших, давтан сурах эрэлт хэрэгцээ их байдаг. Энэ эрэлт хэрэгцээг Мэргэжлийн боловсролын сургууль, ПК-ууд хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд сургалт зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд багшлах хүний нөөц, орчин нөхцөл, байрны орчин бүрдсэн байдаг.

Боловсролын тухай хуулиар гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, өөрийн орлого олох боломж бүрдсэн нь мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бүрэн боломжтой бөгөөд Олон улсын чанарын менежментийн тогтолцоогоор сургалтын байгууллага өөрийн төгсөгчдийг давтан сургах, мэргэшүүлэх эргэх холбоотой байх шаардлага тавигддаг.

1.2 “Хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлттэй агуулах, зоорийн засвар, үйлчилгээ” чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн зарим заалтыг дурдвал:

- Хуулийн 3.1.6 дахь заалтад “мэргэжлийн сургалт” гэж хувь хүний хэрэгцээнд нийцсэн, эсхүл хөдөлмөр эрхлэхэд шаардагдах чадамжийг богино хугацаанд эзэмших сургалтыг;
- Хуулийн 4.1 дэх хэсэгт “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино”;
- Хуулийн 6.4 дэх хэсэгт “Мэргэжлийн сургалтын агуулгыг суралцагчид мэргэшлийн түвшний ур чадвар, чадамжийг эзэмшүүлэх, мэргэшлийн түвшин ахиулах чиглэлээр тогтооно”;
- Хуулийн 9.1 дэх хэсэгт “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага нь техникийн боловсролын, мэргэжлийн боловсролын,

- мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна”;
- Хуулийн 9.2 дахь хэсэгт “Техникийн боловсролын сургалтын байгууллага нь политехник коллеж байна”;
 - Хуулийн 9.3 дахь хэсэгт “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн боловсролын сургууль байна”;
 - Хуулийн 9.4 дэх хэсэгт “Мэргэжлийн сургалтын байгууллага нь сургалтын төв байна”;
 - Хуулийн 9.5 дахь хэсэгт “Политехник коллеж нь мэргэжлийн боловсролын, мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно”;
 - Хуулийн 9.6 дахь хэсэгт “Мэргэжлийн боловсролын сургууль нь мэргэжлийн сургалтын болон бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно”;
 - Хуулийн 9.7 дахь хэсэгт “Мэргэжлийн сургалтын төв нь мэргэжлийн анхан шатны ур чадвар эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалтыг эрхэлнэ”;
 - Хуулийн 13.1 дэх хэсэгт “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгчид дараах боловсролын баримт бичгийг олгоно:
 - 13.1.1.мэргэжлийн сургалтад хамрагдаж чадамж эзэмшсэн иргэнд чадамжийн гэрчилгээ;
 - 13.1.2.мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчид мэргэжлийн үнэмлэх;
 - 13.1.3.техникийн боловсрол эзэмшсэн төгсөгчид диплом.
 - Хуулийн 13.2 дахь хэсэгт “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 13.1-д заасан боловсролын баримт бичгийг олгоно” гэж заасны дагуу тус боловсруулсан Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллеж, мэргэжлийн сургалтын төвүүд тус хөтөлбөрөөр сургалтуудыг зохион байгуулж, шаардлага хангасан төгсөгчдөд “Чадамжийн гэрчилгээ” олгох бүрэн боломжтой үндэслэл бий болж байна.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

Энэхүү хөтөлбөрийн боловсруулалтын давуу тал болон чадамжид суурилсан онцлогийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 2.1 Хөтөлбөрийн бүтэц нь Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн ерөнхий танилцуулга, чадамжийн нэгжийн жагсаалт хэсгээс бүрдэнэ. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 3.1.1 дахь хэсэгт “чадамжид суурилсан сургалт” гэж ажил, мэргэжлийн стандартад тодорхойлсон чадамж эзэмшихэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг, “чадамж” гэж мэдлэг, ур чадвар, хандлагын цогцыг, чадамжийн нэгж (Unit of competence)-ийг “тодорхой ажил, мэргэжлийн чадамж эзэмшихэд чиглэсэн харилцан уялдаа бүхий сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн”-ийг хэлнэ гэж тодорхойлсон. Зарим олон улсын эх сурвалжид чадамжийн нэгжийг “Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгддөг гүйцэтгэлийн үнэлэмжийн хамгийн бага нэгж” гэж тодорхойлдог бөгөөд ихэвчлэн үр дүнгээр хэмжигдсэн үйл үгээр төгссөн байна. Мөн тодорхой ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлдог. Иймд модуль бүрээр чадамжийн нэгжийн агуулгыг судлан тодорхойлолтыг боловсруулсан ба хэмжигдэхүйц, үйл ажиллагаанд үндэслэн боловсруулсан.
- 2.2 Чадамжийн элемент /Element of competence/ нь аливаа чадамжийн нэгжид хамаарах ажилбар, даалгаврыг гүйцэтгэх, чадамжтайгаа харуулахын тулд биечлэн гүйцэтгэж үзүүлэх шаардлагатай үйл ажиллагаануудыг тодорхойлж буй чадамжийн нэгжийг бүрдүүлэгч үндсэн хэсгийн нэг бөгөөд чадамжийн элемент нь чадамжийн нэгжийн дагуу гүйцэтгэх ажлын гол хэсгүүд буюу ажилбарыг хийж, гүйцэтгэхэд шаардлагатай үйлдлүүдийг тодорхойлсон байдаг.
- 2.3 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /Performance criteria/ нь Чадамжийн нэгжийн нэг хэсэг бөгөөд суралцагч эзэмших шаардлагатай гүйцэтгэлийн түвшинд чадамжтай болсон эсэхийг үнэлж тодорхойлдог үнэлгээний хэрэгсэл буюу хүрсэн байх үр дүн юм. Агуулгын гол гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг ажил мэргэжлийн стандартад үндэслэн боловсруулж, хүндрэлийн зэрэг, шинэ гарсан журам, дүрэмтэй харьцуулан мэргэжлийн багш нар тодорхойлж гаргасан.
- 2.4 Гүйцэтгэлийн цар, хүрээ нөхцөлийг ажлын байрны стандарт, шаардлагын дагуу ЧН-ийн гүйцэтгэлийг хангахад ХАБЭА-н дагаж мөрдөх журам, дүрэм, ажлын хүрээнд хамтран ажиллах хүмүүс, ажил гүйцэтгэх зааварчилга, орчин нөхцөл /өндөрт, гадна, дотор, газрын гүнд, халуун, хүйтэн гэх мэт/-ийг тодорхойлж Ажил мэргэжлийн стандартаас холбогдох мэдээллийг авч ашигласан болно.
- 2.5 Чадамжийн элементийн төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байхаар боловсруулсан. Үүнд:

- Элемент тус бүрээр төлөвлөсөн
- Мэдлэг, ур чадвар, хандлагыг ГШҮ-ийн агуулгыг багтаан тус тусад нь боловсруулсан
- Эзэмшвэл зохих мэдлэг нь мэдээллийг ойлгох, хэрэглэх чадвар бөгөөд үйл ажиллагаанд чиглэсэн, үйл үг болон нэр үгээр төгссөн байна. Жишээ нь, ажлын зураг унших, бүдүүвч зураг болон тоо ширхэгийн жагсаалт гаргах, ажлын алхам болон дарааллыг төлөвлөх, явуулах ба хянах, үйлдвэрлэлийн болон ажлын зааварчилгааг мөрдөж ажиллах, чадвар нь мэдлэгийг ашиглаж асуудал шийдвэрлэх үйл ажиллагаа тул үйлдэл заасан үйл үгээр төгсөнө. Хандлагыг хувь хүний чадамжаар тодорхойлсон.

2.6 Чадамжид суурилсан хөтөлбөрөөр сургалт зохион байгуулахад дараах давуу тал үүснэ.

Суралцагчийн хувьд	Байгууллага, сургалтын төвүүд	
Суралцах хугацаа богино	Хүнээ чадваржуулах нэг боломж	Сургалт зохион байгуулах хувилбаруудтай болно.
Сурах өдрийг өөрөө сонгох боломжтой	Ажлын хуваарьт тохируулж зохицуулж болно	Уян хатан цагийн хуваарь гаргаж болно.
Хөтөлбөр буюу чадамж сонгох боломжтой	Хөтөлбөр сонгох боломжтой	Хөтөлбөр сонгох боломжтой
Тодорхой чадамжийг эзэмшинэ	Ажилтны чадамжийг тодорхойлоход хялбар	Чадамжийн тодорхой хичээлийн файлууд бүрдэнэ.
Өөрийн үнэлгээ нэмэгдэнэ.	Үнэлгээ цалин хөлсийг тогтооход дөхөмтэй	Чадамж үнэлэх нөхцөл бүрдэнэ.
Өөрийгөө тодорхойлж чадах учир өсөх дэвших, сурч мэдэх хандлага нэмэгдэнэ.	Мэргэжлийн хүмүүсийг бэлтгэж авах, сургах сайн нөхцөл бүрдэнэ.	Багш нарын бүрэлдэхүүнийг тодорхой чадамжаар бүрдүүлэх боломжтой болно.
Өмнөх ур чадвараа үнэлүүлэх бололцоо бүрдэнэ.	Үнэлүүлсэн ЧАДВАРТАЙ хүнийг ажилд авах боломж бүрдэнэ.	Хөтөлбөрүүдийн дагуу хичээлийн хэрэглэгдэхүүн, ашиглах материал тодорхой болох тул хичээлийн бэлтгэл ажил тодорхой болно.
Ур чадвар өсч, өөртөө итгэлтэй, мэргэжилдээ сайн хандлага төлөвшинө.	Чадамжтай ажилтан бэлтгэгдэнэ.	Багш нарын өгч буй мэдээлэл зөрүүгүй болно.

ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ АШИГЛАХ ХУВИЛБАРУУД

1-р хувилбар:

- Сургалтын эрэлт хэрэгцээ, суралцагч өөрийн ажлын нөхцөл, хугацааг сонгож Модуль тус бүрийг нэг нэгээр сонгох боломжтой.
- Суралцагч хугацааг өөрөө сонгох боломжтой бөгөөд сургалтын байгууллага сонгох боломжийг бүрдүүлж, тайлбарлана.
- Суралцагч хэзээ сургалтад хамрагдахаа сонгох боломжтой бөгөөд сургалтын байгууллага зохион байгуулалтыг хийнэ.

2-р хувилбар:

- Модуль 1, 2 эсвэл 3, 4 гэх мэт модулиар сонгож сурах боломжтой.

3-р хувилбар:

- Бүх модулийг сонгож сурах боломжтой

Хүснэгт 1. Сургалтын хөтөлбөр ашиглах хувилбарууд

Хувилбар	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Модуль 1												
Модуль 2												
Модуль 3												
Модуль 4												

Тайлбар: Модулиудыг өнгөөр ялгаж, хувилбарыг дугаараар тэмдэглэв. Нийт 12 хувилбар байх боломжтой.

	Модуль 1		Модуль 2		Модуль 3		Модуль 4
--	----------	--	----------	--	----------	--	----------

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

4.1 Анхаарах зүйл: Боловсруулсан хөтөлбөрийг ашиглахад дараах зүйлийг анхаарна уу.

- “Хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зөв дадал (GSP)-д тулгуурласан чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр нь “Хөргөлтийн тоног төхөөрөмжийн техникч” мэргэжлийн ажил мэргэжлийн стандартад тулгуурлан боловсруулсан байгаль орчинд ээлтэй хөргөх бодисыг сонгох, хөргөх бодистой холбоотой эрх зүйн орчны тухай, засвар үйлчилгээний үед хөргөх бодистой (R717, R744, R290, R600a) харьцахдаа аюулгүй орчинг бүрдүүлэх, МУ-д хөргөлттэй агуулахын

төхөөрөмжид түлхүү ашиглаж буй HCFC-ийн бүлгийн R22 болон R404A хөргөх бодисын алдагдал илрүүлэх, хөргөх бодисыг юүлэх, дахин ашиглах, системийг вакуумдах, системийг хөргөх бодисоор цэнэглэх, хөргөлтийн системийн даралтыг шалгах, хөргөлтийн компрессорт үзлэг үйлчилгээ хийх, хөргөлтийн тоног төхөөрөмжийг ажиллуулж шалгах, ууршуулагчид үзлэг үйлчилгээ хийх, хөргөлтийн конденсаторт үзлэг үйлчилгээ хийх, цахилгаан, автомат төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ хийх, хэмжих, хянах хэрэгсэлд үзлэг үйлчилгээ хийх, гэмтлийн шалтгааныг тодорхойлох, хөргөх бодисыг ресиверт хураах, хөргөлтийн компрессор засварлах, цахилгааны гэмтлийг засварлах, конденсатор засварлах, ууршуулагч засварлах мэдлэг, ур чадвар, хандлага олгох боломжтой модульчилсан чадамжид суурилсан сургалтын арга зүйгээр зохион байгуулахад зориулсан хөтөлбөр юм.

- Сургалтын хөтөлбөр нь 21 чадамжийн нэгжээс бүрдэх ба нийт 160 цагийн агуулгатай, богино хугацааны, мэргэшүүлэх, давтан сургах гэх мэт олон хувилбараар ашиглаж болох бөгөөд бүх чадамжийг үргэлжлүүлэн сурах тохиолдолд 20 өдрийн онол, дадлагын сургалт хосолсон хэлбэрээр зохион байгуулж болно.
- Сургалтын хөтөлбөрт ЧН-ийн тодорхойлолт, Өмнө нь эзэмшсэн байх ЧН, Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт (Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, ЧН-д оногдох цаг), Гүйцэтгэлийн цар хүрээ, нөхцөл, сургалт зохион байгуулахад тавигдах шаардлага багтсан. Мөн Үнэлгээний төлөвлөгөө, сургалтын орчин, хэрэглэгдэх багаж хэрэгслийн жагсаалт, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, хичээлийн хуваарь багтсан.
- Модуль 1-д 3 чадамжийн нэгж, Модуль 2-д 5 чадамжийн нэгж, Модуль 3-д 7 чадамжийн нэгж, Модуль-4-д 6 чадамжийн нэгж, нийт 21 чадамжийн нэгжийг багтаасан тул чадамжид суурилсан сургалтын арга зүйд нийцүүлэн уян хатан сонгох хуваарь боловсруулах, суралцагч өөрөө хугацаа болон чадамжийн нэгжийг сонгох боломжтой юм.
- Сургалтын байгууллага нь суралцагч өөрсдийн цаг, хугацаа, мэдлэг, чадвараас хамааран олон төрлөөр сонгон суралцах байдлаар зохион байгуулалтыг хийх боломжтой юм.
- Сургалт зохион байгуулахад үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэнэ.
- Мөн өмнө нь олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлэх бололцоо бүрдэхээс гадна модуль тус бүрийн үнэлгээний төлөвлөгөөг ашиглан өмнө нь ажиллаж байсан туршлага, мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх үнэлгээг хийж болно.

4.2 Сургалтын байгууллагуудад зөвлөхөд:

- 4.2.1 Тухайн “Хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлттэй агуулах, зоорийн хөргөлтийн засвар үйлчилгээ” Модуль сургалтын хөтөлбөрийг бүх төрлийн

- (МБС, ТБОС, Мэргэжлийн сургалтын төв, Их, дээд сургууль) сургалтын байгууллага болон цаашлаад үйлдвэр, аж ахуй нэгжүүд ажлын байран дээр мэргэжлийн багш, инженер, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах боломжтой;
- 4.2.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 784 дугаартай Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дүгнэлтээр баталгаажсан тул сургалтын байгууллага, аж ахуй нэгж инженер, техникийн ажилтнууд, хүнс, худалдааны хөргөлтийн чиглэлээр суралцах сонирхолтой иргэд, залуучуудыг модульчилсан сургалтаар сургах, чадавхжуулах, давтан сургах зорилгоор хэрэгжүүлэх боломжтой;
- 4.2.3 Сургалт нь багш, суралцагчийн хамтын үйл ажиллагааны нэгдэл бөгөөд сургалтыг хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг тул хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, сурах, сургах арга зүй, үнэлгээний арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, тэдгээрийн хоорондын нарийн уялдаатай үйл явцыг төлөвлөж ашиглах боломжтой.
- 4.2.4 Энэхүү хөтөлбөр нь хөргөх бодисын алдагдал илрүүлэх, системийн битүүмж шалгах, системийг вакуумдах, хөргөх бодисоор цэнэглэх, юүлэх засвар үйлчилгээнд зөв дадал (GSPs)-ыг хүнс үйлдвэрлэл, худалдааны хөргөлтийн тоног төхөөрөмжийн засварчдад зайлшгүй эзэмшүүлэх шаардлагатай тул тус модулиудын хувилбараас сонгон ашиглахыг зөвлөж байна.
- 4.2.5 Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд мэргэжлийн багшийг бэлтгэж сургах зайлшгүй шаардлагатай;
- 4.2.6 Хөтөлбөр нь онол, дадлагын харьцааг 25:75 байхаар тодорхойлсон бөгөөд дадлагын сургалт голлон зохион байгуулах учир сургалтын орчныг бүрдүүлэх, зохих хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр тоноглох шаардлагатай;
- 4.2.7 Дадлага хийх нөхцлөөр үйлдвэр, ААН, хувь хүн хангах, хамтран ажиллах
- 4.2.8 Суралцагчдад эртнээс сургалтын тухай мэдээллийг өгөх
- 4.2.9 Багш, сургагч буюу ажлын байран дээрх дадлагажуулагчийг бэлтгэх
- 4.2.10 Суралцагчийг хөтөлбөрийн модулиудын хувилбараас сонгон суралцах боломжоор хангаж, сургалтын уян хатан зохион байгуулалтыг хийж ажиллахыг зөвлөж байна.

4.3 Сургагч багшид зөвлөхөд:

- 4.3.1 Төгсөлтийн үнэлгээний төлөвлөгөөг дэлгэрэнгүй боловсруулсан тул сургагч багш явцын үнэлгээний хэсгийг өөрөө боловсруулан ашиглах боломжтой;
- 4.3.2 Энэ хөтөлбөрийг багш өөрөө өөр төрлийн хөргөх бодисын хувьд тохируулан ашиглаж болох ба өмнөх мэдлэг ур, чадвар (RPL)-ын үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг (ажил мэргэжлийн стандартад үндэслэсэн тул) ашиглаж болно;
- 4.3.3 Модуль хөтөлбөрийг ашиглах сургагч багш нь сургалтын үед ажлын даалгаврыг

боловсруулан, түүнд тохирсон тоног, төхөрөөмж, багаж хэрэгсэл, материалын тооцоог дэлгэрэнгүй хийж ашиглах;

- 4.3.4 Сургагч багш нь сургалтад шаардлагатай гарын авлага, ном зэргийг бэлтгэж, боловсруулах зэргээр баяжуулан ашиглах боломжтой;
- 4.3.5 Тус хөтөлбөрөөр хичээл заах сургагч багш нь чадамжид суурилсан сургалтын талаарх суурь ойлголт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад мөрдөх стандарт, дүрэм, журмуудын талаар, чадамжид суурилсан заах арга зүй, үнэлгээний арга зүйг эзэмшсэн, тус хөтөлбөрийг ашиглах, хэрэглэх чадвартай байх шаардлалтай юм.
- 4.3.6 Орчин үеийн мэргэжлийн хөтөлбөр/чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр/-ийг ашиглах, хэрэглэх нь нэг талаас багшаас өндөр мэдлэг, ур чадвар, нөгөө талаас багш олон талын мэдээлэл, эх сурвалж уншиж, судалж үүнтэй холбоотой хөдөлмөр, цаг хугацаа их шаарддаг онцлогтой тул багш та илүү ихийг сурч, хөгжихийг хүсвэл мэргэжлийн хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалтад гүнзгий суралцан мэдлэг, мэргэшлээ тасралтгүй хөгжүүлэхийг зөвлөж байна.

4.4 Суралцагч, иргэнд зөвлөхөд:

- 4.4.1 Өмнөх мэдлэг, ур чадвараа үнэлүүлэхийг хүссэн иргэн, энэ хөтөлбөрөөр сурах хүсэл сонирхолтой болон мэргэшихийг хүсч байгаа иргэд тухайн хөтөлбөрөөр суралцах боломжтой.
- 4.4.2 Энэхүү сургалтын хөтөлбөрийн Үнэлгээний төлөвлөгөөг “Өмнөх мэдлэг, чадварыг үнэлэх” (RPL)-д ашиглах боломжтой;
- 4.4.3 “Өмнөх мэдлэг, чадварыг үнэлэх” үнэлгээ (RPL)-д ороод эхний удаа тэнцээгүй оролцогч, иргэд сургалтад хамрагдах боломжтой;
- 4.4.4 Суралцагч нь хөтөлбөрийн модулиудын хувилбараас сонгон суралцах боломжтой.

МОДУЛЬ 1

МОДУЛЬ 1 ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код
Модуль 1		
1	Байгаль орчинд ээлтэй хөргөх бодис сонгох	0713-08-01
2	Засвар үйлчилгээний үед хөргөх бодистой харьцах	0713-08-02
3	Хөргөх бодисыг юүлэх, дахин боловсруулах	0713-08-03

“БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ХӨРГӨХ БОДИС СОНГОХ” ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН БҮТЭЦ

Чадамжийн нэгжийн нэр: Байгаль орчинд ээлтэй хөргөх бодис сонгох
Чадамжийн нэгжийн код: 0713-08-01 ¹
Чадамжийн нэгжийн тодорхойлт: Тус чадамжийн нэгжийн хүрээнд Озоны давхарга, түүний ач холбогдол, Озоны цоорхой, түүний сөрөг нөлөө, Монреалийн протоколын зорилго, зорилт, хөтөлбөрийн хүрсэн үр дүн, гэрчилгээжүүлэлтийн журам, стандартын ач холбогдол, холбогдох стандартад, хууль тогтоомжууд, импортын зөвшөөрлийн талаарх мэдлэг, хандлага эзмшихэд (эзэмшүүлэхэд) чиглэнэ.
Өмнө нь эзэмшсэн байвал зохих чадамжийн нэгж: - Хөргөлтийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр ажиллаж байгаа болон ажилласан туршлагатай, ажиллах хүсэлтэй иргэд Эсвэл: - Хүнс үйлдвэрлэл, худалдааны салбарт хөргөлтийн тоног төхөөрөмжийн чиглэлээр ажилласан олон жилийн дадлага туршлагатай байж болно. - Мэргэжлийн боловсрол, сургалтын Хөргөлт, агааржуулалтын салбарын мэргэжлээр суралцсан, мэргэжлийн үнэмлэхтэй байж болно. - Хөргөлт, агааржуулалт, цахилгаан, механик болон инженерийн чиглэлээр бакалавр түүнээс дээш зэрэгтэй байж болно.

¹ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/11 дүгээр “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтад 071 төрөлжсөн чиглэлийн, 0713 нарийвчилсан чиглэлд 0713-08 мэргэжлийн индексээр “Хөргөлт, агааржуулалтын тоног төхөөрөмжийн угсралт, засвар үйлчилгээ” нэрээр орсныг 0713-08-01, 0713-08-02……… 0713-08-21 гэж чадамжийн нэгжийг дараа дараагийн чадамжийн нэгжтэй давхцуулахгүйн тулд эрэмбэлэн дугаарласан. Мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсрол, мэргэжлийн сургалтаар ямар ажил, мэргэжлийг ямар түвшинд бэлтгэх боломжтойг тодорхойлох тул түвшин заагаагүй болно.

Чадамжийн нэгжийн агуулгын төлөвлөлт:

	Чадамжийн элемент	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Анги дүүргэлт:10-15		
			Чадамжийн нэгжийн цаг: 6		
			Онол	Дадлага	Чадамжийн элементэд ноогдох цаг
1	Хөргөх бодистой холбоотой хууль эрх зүй, дүрэм журам, стандартыг тайлбарлах	1.1. Хөргөх бодисын озоны давхаргад үзүүлж буй нөлөөлөл, тэдгээрийн ОЗЧ, ДДНЧ-ийн талаар мэдээлэл 1.2. Хөргөх бодистой холбоотой Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомжууд, хэрэгжилт 1.3. Хөргөлттэй агуулах, зоорийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, хөгжлийн чиг хандлага, цаашид хөргөх бодистой холбогдож буй асуудал 1.4. Хог хаягдлын тухайн хуулийг тайлбарлах	1		1
2	Озоны үе давхарга, байгаль орчныг хамгаалах	2.1 Озоны давхарга ба озон бүрэлдэн бий болох; озоны давхаргын үүрэг, озоны давхаргын задрал, түүний үр дагавар 2.2 Озон задалдаг бодис (ОЗБ), түүний озон задлах процессыг судлах 2.3 Озон задалдаг бодис, түүний уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг судлах – Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) 2.4 Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, доройтуулах үйл ажиллааны талаар тайлбарлах	1		1
3	Монреалийн протокол”, түүгээр Монгол Улсын хүлээх үүргийг тайлбарлах	3.1 Монреалийн протокол, нэмэлт, өөрчлөлт 3.2 Монреалийн протоколын хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд 3.3 Монгол Улсын хүлээж буй үүрэг, зорилтууд 3.4 Гидрохлорфторт нүүрстөрөгч (HCFC/ГХФН)-ийн бодисын хэрэглээг үе шаттай бууруулж хэрэглээнээс халах, гидрофторт нүүрстөрөгч (HFC/ГФН) төрлийн бодисын хэрэглээг үе шаттай бууруулах, түүнтэй холбоотой бодлого, дүрэм журмыг судлах	1		1
4	Хөргөх бодис, түүний төрөл, тэдгээрийн шинж чанарын талаар ойлголт	4.1 Хөргөх бодисын төрөл, шинж чанар, нэршлийг судлах/тайлбарлах 4.2 Озон задалдаг буюу байгаль орчинд сөрөг нөлөөтэй хөргөх бодисын хэрэглээг бууруулахад хувь нэмэр оруулах	1		1

		4.3 Хөргөлтийн тоног төхөөрөмжийн тос, ангилал, шинж чанар 4.1. Хөргөх бодис болон тосны нийцэл, зохицол			
Нийт цаг			4	2	6
Онол дадлагын цагийн харьцаа			67:33		

Тайлбар: Сургалтын 1 цагийг 45 минутаар тооцсон болно.

Гүйцэтгэлийн цар хүрээ, нөхцөл:

ХАБЭА -н ажлын дадлагын асуудлууд	Үүнд: - Ажилчдын ажлын эрсдэлт орчныг үнэлэх - Ажиллагсдын туршлага байгаа эсэх - Аюултай/эрүүл бус захиргааны зохицуулалт (ажлын урт хугацаа, завсарлагагүй, байнгын илүү цагаар ажиллах, ажлын хуваарь гаргах,) - Хувийн хамгаалах хэрэгсэл эсвэл ХАБЭА-н бусад журам, удирдамжийг ашиглах, дагаж мөрдөхгүй байх шалтгаан
ХАБЭА -н үзүүлэлтүүд	Үүнд: - Осол, бэртэл гэмтэл, хордлогын тохиолдол нэмэгдсэн эсэх - Өвчин, эрүүл мэндийн гомдол/шинж тэмдгийн илрэл нэмэгдэх - ХАБЭА -тай холбоотой ажилчдын нийтлэг гомдол - Ажилтай холбоотой шалтгаанаар тасалдсан байдал өндөр байгаа эсэх
ХАБЭА -н ажлын заавар	Үүнд: - Аюулыг арилгах (жишээ: аюулгүй орчныг бүрдүүлэх нөхцлийг хангах, тухайн хөргөх бодист тохирсон багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалалтын хэрэгслээр хангах) - Эрсдэлийг бууруулахын тулд захиргааны хяналтыг ашиглах (жишээ: тоног төхөөрөмжийг хэрхэн аюулгүй ашиглах талаар сургалт явуулах; R717, R744, R290, R600a бодисуудтай ажиллах үеийн эрсдэлийг бууруулахтай холбоотой анхааруулах тэмдэг тавих, ажиллагсдын мэдлэгийг тодорхойлох шалгалт авч байх) - Эрсдэлийг бууруулахын тулд инженерийн хяналтыг ашиглах (жишээ: эрсдэлт орчныг хянах, хувийн хамгаалалтын хэрэгслийн хэрэглээ, зориулалтын тоног төхөөрөмжийн хангамжийг хянаж шалгах) - Хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах байдлыг хянах,, тогтмол хэрэглэж сурах дадлыг бий болгох - Аюулгүй байдал, эрүүл мэнд, ажлын орчны үнэлгээг хийж байх - Ажилчдыг үе үе болон эсвэл тусгай эрүүл мэндийн үзлэгт хамруулах
ХАБЭА -н хэмжигдэхүүн	Үүнд: - Осол, гэмтлийн тохиолдлын статистик - Өвчлөл (Өвчний төрөл ба тоо) - Нас баралт (нас баралтын шалтгаан ба тоо) - Ослын түвшин

ЧАДАМЖИЙН ЭЛЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЧЭ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Чадамжийн элементийн мэдлэг, чадвар, хандлага
1	1.1 Хөргөх бодисын озоны давхаргад үзүүлж буй нөлөөлөл, тэдгээрийн ОЗЧ, ДДНЧ-ийн талаар мэдээлэл 1.2 Хөргөх бодистой холбоотой Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомжууд, хэрэгжилт 1.3 Хөргөлттэй агуулах, зоорийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, хөгжлийн чиг хандлага, цаашид хөргөх бодистой холбогдож буй асуудал 1.4 Хог хаягдлын тухай хууль, түүнийг дагалдаж гарсан дүрэм, журмыг тайлбарлах	Мэдлэг: - Хөргөх бодисын озоны давхаргад үзүүлж буй нөлөөлөл, тэдгээрийн ОЗЧ, ДДНЧ-ийн тухай - Хөргөх бодистой холбоотой Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомжууд - Хөргөлттэй агуулах, зоорийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, хөгжлийн чиг хандлага, цаашид хөргөх бодистой холбогдож буй асуудал - Хөргөх бодист тавигдах термодинамикийн шаардлагууд - Хог хаягдалтай холбоотой дүрэм, журам - Хөргөх бодис, хөргөлтийн тоног төхөөрөмж болон түүнтэй холбоотой хог хаягдлын тухай Ур чадвар: - Хөргөх бодист тавигдах шаардлагуудын талаарх мэдлэгтээ тулгуурлан мэдээллийг боловсруулах - Байгаль орчинд ээлтэй хөргөх бодис сонгох
2	2.1 Озоны давхарга ба озон бүрэлдэн бий болох, озоны давхаргын үүрэг, озоны давхаргын задрал, түүний үр дагавар 2.2 Озон задалдаг бодис (ОЗБ), түүний озон задлах процессыг судлах 2.3 Озон задалдаг бодис, түүний уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөллийг судлах – Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (ДДНЧ) 2.4 Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, доройтуулах үйл ажиллааны талаар тайлбарлах	Мэдлэг: - Озон, озоны давхарга - Озоны давхаргын задрал - Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт - Байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл - Озоны давхарга, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй нөлөөллийг бууруулах арга зам Ур чадвар: - Озоны давхарга, түүний ач холбогдлыг тайлбарлах - Озоны давхаргын цооролоос үүдэх сөрөг нөлөөллийг тайлбарлах - Озоны давхарга, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж буй нөлөөллийг бууруулах арга замуудыг тайлбарлах - Озоны үе давхарга, байгаль орчныг хамгаалах
3	3.1 Монреалийн протокол, нэмэлт, өөрчлөлт 3.2 Монреалийн протоколын хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд 3.3 Монгол улсын хүлээж буй үүрэг, зорилтууд 3.4 Гидрохлорфторт нүүрстөрөгч (HCFC/ГХФН)-ийн бодисын хэрэглээг үе шаттай бууруулж хэрэглээнээс халах, гидрофторт	Мэдлэг: - Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай - Монреалийн протокол, түүний Кигалийн нэмэлт, өөрчлөлт - Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколоор хүлээх үүрэг Ур чадвар: - Монреалийн протоколын талаарх

	нүүрстөрөгч (HFC/ГФН) төрлийн бодисын хэрэглээг үе шаттай бууруулах, түүнтэй холбоотой бодлого, дүрэм журмыг судлах	мэдлэгтээ тулгуурлан мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэхдээ тулгамдаж буй асуудлыг ойлгож ухамсарлах
4	4.1 Хөргөх бодисын төрөл, шинж чанар, нэршлийг судлах/тайлбарлах 4.2 Озон задалдаг буюу байгаль орчинд сөрөг нөлөөтэй хөргөх бодисын хэрэглээг бууруулахад хувь нэмэр оруулах 4.3 Хөргөлтийн тоног төхөөрөмжийн тос, ангилал, шинж чанар 4.4 Хөргөх бодис болон тосны нийцэл, зохицол	Мэдлэг: - Хөргөх бодис, түүний төрөл - Озон задалдаг буюу байгаль орчинд сөрөг нөлөөтэй хөргөх бодисын хэрэглээг бууруулах - Хөргөх бодисын шинж чанар - Хөргөх бодисын ангилал, нэршил - Хөргөлтийн тоног төхөөрөмжийн тос, ангилал, шинж чанар - Хөргөх бодис болон тосны нийцэл, зохицол Ур чадвар: - HCFC төрлийн хөргөх бодисыг бууруулах үйлст мэргэжлийн хүний хувьд оруулах хувь нэмэрээ ухамсарлаж, өөрийгөө чадваржуулах хөгжүүлэх
5	5.1 Хөргөх бодис импортлохтой холбоотой гаалийн бичиг баримтыг бүрдүүлэх журам 5.2 Гаалийн бичиг баримтыг бүрдүүлэх	Мэдлэг: - Хөргөх бодис импортлохтой холбоотой эрх зүйн баримтууд Ур чадвар: - Гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл, баримт бичгийн бүрдүүлэлтийг хийх, мэдээлэл, холбогдох бичиг баримтыг уншиж, ашиглах
Эзэмшвэл зохих хандлага, сэтгэлгээний өөрчлөлт		Байгаль орчинд ээлтэй хөргөх бодисыг сонгох, ашиглах, агаарт алдахгүй байх талаар зөв хандлагатай болно. Өндөр даралттай болон шатамхай хөргөх бодисыг ашиглахдаа өөрийн болон бусдын аюулгүй орчныг хангах хариуцлагатай болсон байна.
Сургалт явагдах газар:		- Бодит ажлын байранд болон ажлын байранд бүрдүүлсэн зохиомол орчинд - Эсвэл чадамжийн төв, мэргэжлийн сургалтын төв, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгуулага
Сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт:		- Видео бичлэг - Хөргөх бодистой холбоотой холбоотой гаалийн бичиг баримт бүрдүүлэх маягтууд - Илтгэл (PPT) №1 Хөргөх бодистой холбоотой хууль эрх зүй, дүрэм журам, стандарт - Илтгэл (PPT) №2 Озоны үе давхарга, байгаль орчныг хамгаалах - Илтгэл (PPT) №3 “Монреалийн протокол”, түүгээр Монгол Улсын хүлээх үүрэг - Илтгэл (PPT) №4 Хөргөх бодис, түүний төрөл, тэдгээрийн шинж чанарын талаар ойлголт
Материал, түүхий эдийн жагсаалт:		Шаардлагагүй
Техник, тоног төхөөрөмж, багаж,		Проектор

хэрэгслийн жагсаалт:	Компьютер
Ашигласан материал:	- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тушаалаар баталсан “Техникч, хөргөлтийн тоног төхөөрөмжийн” ажил мэргэжлийн стандарт - Хөргөлтийн арга ажиллагааны сайн арга туршлага, УБ, 2020 - Озоны үе давхаргыг хамгаалах талаар Монгол Улсад дагаж мөрдөх эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, УБ, 2020 - Шатамхай хөргөх бодистой харьцах засвар үйлчилгээний аргачлал: Гарын авлага, УБ, 2021 - Хөргөх бодисыг системээс юүлэх, цэвэрлээд дахин цэнэглэх тоног төхөөрөмжийн ажиллагаа болон техник засвар үйлчилгээний гарын авлага, УБ, 2003 - Хөргөх бодис хлорфторт нүүрстөрөгчийг системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, устгах технологи, УБ, 2007
Дүгнэлт (Сургалтын дараа сургагч багш тухайн элементийн хүрээнд хичээлийг дүгнэж бичнэ)	
Санал, зөвлөмж: (Сургалтын явцад хөндлөнгөөс тухайн сургалттай холбоотой санал зөвлөмж байвал бичнэ.)	

**“ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЕД ХӨРГӨХ БОДИСТОЙ ХАРЬЦАХ”
ЧАДАМЖИЙН НЭГЖИЙН БҮТЭЦ**

Чадамжийн нэгжийн нэр: Засвар үйлчилгээний үед хөргөх бодистой харьцах
Чадамжийн нэгжийн код: 0713-08-02
Чадамжийн нэгжийн тодорхойлт: Энэхүү чадамжийн нэгжийн хүрээнд ажиллах үеийн орчны эрсдэлүүдийг үнэлгээ, тухайн хөргөх бодист тохирох хувийн хамгаалалтын хэрэгслүүд, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бэлтгэх, хөргөх бодисын алдагдлыг илрүүлэх, юүлэх аргуудын онцлогтой танилцах, тосны ангилал ашиглалтын нөхцлийг тодорхойлоход шаардагдах мэдлэг хандлагыг эзэмшинэ.
